

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ 2024 ОНД **ЗАВХАН** АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжилт
1	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулах, хуулийг дагалдан норм стандарт, дүрэм, журмыг боловсруулахад хамтран ажиллах.	Хуулийн төслийг УИХ-аар батлуулсан байна. Холбогдох норм стандарт, дүрэм, журмын төслийг боловсруулж батлуулсан байна.	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулах, хуулийг дагалдан норм стандарт, дүрэм, журмыг боловсруулахад хамтран ажиллах ажил хүлээгдэж байна.
2	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, Хот байгуулалтын кадастрын цахим системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.	Аймгийн төв хотуудын барилга байгууламж, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж, зам, тээврийн өгөгдлийн санг үе шаттайгаар бүрдүүлж, Хот байгуулалтын кадастрын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдэн хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	2024 оны жилийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 3250 барилга байгууламжийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим систем болох /WWW.URBAN.GOV.MN/-д бүртгээд байна. Тохижилт ногоон байгууламжийн мэдээлэл Жилийн эцсийн байдлаар 18 сумын 218 ногоон байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим систем болох /www.urban.gov.mn/-д бүртгэл мэдээллийг бүрэн оруулсан. Инженерийн дэд бүтцийн хэмжээнд Ус хангамж сүлжээний 1046 мэдээлэл, Ариутгах татуургын сүлжээний 626 мэдээлэл, Дэд станы 11 мэдээлэл, Хот байгуулалтын кадастрын цахим систем болох /URBAN.GOV.MN/-д бүртгэгдсэн. Мөн Автозамын сүлжээний мэдээлэл бүрэн бүртгэгдэж дууссан.
3	Аймгийн ерөнхий архитекторын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнг хагас бүтэн жилээр үнэлэн тус яаманд хүргүүлэх.	Үйл ажиллагааг үнэлж ирүүлсэн байна.	Хүлээгдэж байгаа. 4-р улиралд төлөвлөж байгаа.
4	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу “Хот суурин газрыг	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх.	Хийгдээгүй

	дахин хөгжүүлэх төсөл”, арга хэмжээг санаачлах, хэрэгжүүлэхэд санал зөвлөмж авах.		
5	Монгол Улсын Үндсэн хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулинд нийцүүлэн хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох судалгаа, тооцоог боловсруулах ажлын хүрээнд холбогдох мэдээлэл, судалгаагаар хангах, БХБЯ-тай хамтран ажиллах.	Холбогдох мэдээлэл, судалгаагаар хангаж, хамтран ажилласан байна.	Хүлээгдэж байна
6	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн дэд бүтцийн ажил хийгдсэн, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний хүрээнд орон сууцны хороолол барих боломжтой газруудыг орон нутгийн хэрэгцээнд авч, орон сууцны хороолол барих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-тай хамтран ажиллах, санал боловсруулах, холбогдох тооцоо, судалгааг боловсруулах, урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулах.	Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууцны хороолол барих боломж бүхий газрыг өмчлөлд авч, холбогдох тооцоо, судалгаа, ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.	Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын бүсчлэлийн тогтолцооны орон нутгийн хөгжлийн төвөөр тогтоосон 6 бүсийн 88 сумын инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл ажлын хүрээнд манай аймгийн бүлэг суурингийн төв Улиастай, Тосонцэнгэл, Шилүүстэй, Завханмандал, Түдэвтэй, Тэс сумдад төрийн албан хаагчийн 8 айлын орон сууцны газар инженерийн дэд бүтцийн мэдээллийг барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

7	Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууц санг бүрдүүлэх, түрээсийн орон сууцны төсөл хэрэгжүүлэх захиалагчид газар, дэд бүтцийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох. Улирал бүр тус яаманд тайлан, мэдээлэл ирүүлэх.	Орон нутгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан нэмэгдэж, зорилтот бүлгийн иргэд орон сууцаар хангагдах боломж бүрдсэн байна. Газар, дэд бүтцийг олгосон байна.	Улиастай суманд 21-р зуун жишиг хорооллын 800 айлын орон сууцны хорооллын гадна ижнөнөрийн шугам сүлжээний ажил иж бүрэн хийгдсэн. Түрээсийн орон сууцны барилга барих дэд бүтэц газрын асуудал бүрэн шийдсэн.
8	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах бүтцийн нэгжийг байгуулж, орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан амины орон сууц барих бүсүүдийг тодорхойлж, эхний ээлжийн байршлыг нарийвчлан тогтоож, ИТХ-аар батлуулах.	Амины орон сууц барих бүсүүдийг нарийвчлан тогтоож, ИТХ-аар батлуулсан байна.	Монгол Улсын Засгийн газар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Засгийн газраас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Миний анхны байр, миний орон нутагт амьдрах сонголт”, Миний түрээсийн байр”, “Миний амины орон сууц”, Миний сонголт нийтийн албан хаагч” зэргээр төрөлжүүлэн нэмэгдүүлэхэд газрын харилцааны чиглэлээр дэмжлэг үзүүлэх зорилгоор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд орон сууц, амины орон сууцны зориулалтаар эзэмшүүлэх боломжтой газрын байршил хэмжээг тогтоон ГЗБГЗЗЕГ-т газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 34 тоот албан бичгээр судалгааг хүргүүлсэн бөгөөд ИТХ-аар батлуулах ажлыг 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч ажил хүлээгдэж байна.
9	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага MNS 6877:2020 стандартын хэрэгжилтийг хангуулж, ажиллах.	Амины орон сууцны зориулалттай газрын ашиглалт, нөхцөл сайжирсан байна.	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага MNS 6877:2020 стандартын хэрэгжилтийг хангуулах талаар иргэд олон нийт цахимаар дамжуулан суртчилах ажлыг зохион байгуулж байна.
10	Газар хөдлөлт болон галд тэсвэртэй, хөрсний бохирдолгүй, ариун цэврийн болон эрчим хүчний хэмнэлттэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан, тухайн орон нутгийн цаг уур, бүс нутгийн	Нэг маягийн загвар зураг боловсруулагдаж, иргэдэд хүрсэн байна	ШУТИС-ын эрчим хүчний хэмнэлтийн төвөөс гаргасан 54 м2 болон 36 м2 талбайтай нэг маягийн эрчим хүчний хэмнэлттэй барилгын зураг төсвийг үнэ төлбөргүй ашиглуулж байна.

	онцлогт тохирсон, хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай хамтран боловсруулж батлуулан, иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах.		
11	Монгол Улсын хэмжээнд 2024 оныг бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарласан болон хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд шилжин суурьших хүсэлтэй иргэн, өрхөд шаардлагатай амьдрах, оршин суух газрыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу саадгүй олгож ажиллах.	Шилжин суурьших хүсэлтэй иргэн, өрхөд амьдрах, оршин суух зориулалттай газрыг саадгүй олгосон байна. Тоо хэмжээ: Гомдол үүсээгүй байх.	2024 онд шилжин суурьших хүсэлтэй иргэнд газрын хүсэлт ирээгүй байна.
12	Нийтийн эдэлбэр газрыг бүртгэлд авах, зориулалтын дагуу ашиглах, хамгаалах, хяналт тавих чиглэлээр хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээг авч ажиллах	Нийтийн эдэлбэр газрыг бүртгэлжүүлж, хил зааг солбилцлыг баталсан байна.	Нийтийн эдэлбэр газрыг бүртгэлд авах, зориулалтын дагуу ашиглах, хамгаалах, хяналт тавих чиглэлээр хууль тогтоомжид заасны дагуу хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийтийн эдэлбэр газраас төлөвлөгдсөн арга хэмжээний дагуу хил зааг солбицлыг баталсан байна.
13	Ундны усны эх үүсвэр түүний тэжээгдлийн муж, усны сан бүхий газрын хориглолт, хамгаалалтын бүсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тогтоон баталгаажуулах, Газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх	Хориглолт, хамгаалалтын бүсийг тогтоон баталгаажуулж, мэдээллийн санд бүртгэсэн байна.	Усны сан бүхий газрын хориглолт, хамгаалалтын бүсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу 1043 газрын хамгаалалтын зурвасыг Газрын зохион байгуулалтын хот төлөвлөлтийн цахим системд оруулж баталгаажуулсан байна.
14	Төвлөрсөн инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, авто зам, төмөр замын хяналтын	Хамгаалалт, хяналтын зурвас газрыг тогтоон баталгаажуулж, мэдээллийн санд бүртгэсэн байна.	Төвлөрсөн инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, авто замын зурвас газрыг хууль тогтоомжид заасны дагуу нийт Тосонцэнгэл, Сонгино, Нөмрөг, Улиастай сумдын хатуу авто замын хамгаалалтын зурвасын Газрын удирдлагын

	зурвас газрыг хууль тогтоомжид заасны дагуу тогтоон баталгаажуулах, Газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх		нэгдсэн мэдээллийн санд бүртгэж баталгаажуулсан байна.
15	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байгаа сумдад өндөржилт төлөвлөлтийн ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө, сумын хөгжлийн сан болон бусад техник тусалцаа, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах	Өндөржилт төлөвлөлтийн ажил зохион байгуулагдсан байна.	Тосонцэнгэл суманд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил эхлэхтэй холбогдуулан өндөржилт төлөвлөлтийн ажил тухайн сумын орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө нь шийдвэрлэгдэж хийгдсэн байна.
16	Шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай сум төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг БХБЯ-тай хамтран хэрэгжүүлэх.	2024 онд 1-2 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан байна	. Завхан аймгийн Тосонцэнгэл суманд сумын төвийн хотын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахаар Төндэрт шалгарсан гүйцэтгэгч компани “Циркул проект” ХХК-нь суурин судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна.
БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР			
17	Монгол Улсын Их хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах	Тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Барилга байгууламжид биет үзлэг хийж, буулган шинээр барихад шаардлагатай төсвийг шийдвэрлэж ажлыг эхлүүлэх мөн Газар хөдлөлтөд тэсвэртэй хүчитгэх шаардлагатай барилга байгууламжийн судалгааг гаргаж шаардлагатай төсвийг шийдвэрлэж ажилласан байна	. Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа сургууль, дотуур байр, спорт заалны 138 барилга, цэцэрлэгийн 41 барилга, эрүүл мэндийн 44 барилга, үзвэр үйлчилгээ соёлын төвийн 25, ЗДТГ, зочид буудал бусад олон нийтийн барилга-35, орон сууцны -44 барилга үйлдвэрийн барилга-5, сумдын дулааны шугам сүлжээ-24, Алдархаан, Отгон Улиастай, Тосонцэнгэл сумын цэвэр бохир усны шугам, усан сан, цэвэрлэх байгууламж байна. Цэцэрлэгийн 44 барилгаас шаардалага хангахгүй Отгон, Нөмрөг, Түдэвтэй, Тосонцэнгэл сумын 1 ба 4 цэцэрлэг, Улиастай сумын 6-р цэцэрлэг зэрэг 6 барилгаас Түдэвтэй, Отгон, Улиастай сумын-6 цэцэрлэг, Тосонцэнгэл сумын 1-р цэцэрлэгийн барилгын зураг төслийг шинээр хийлгэж Түдэвтэй Отгон сумын цэцэрлэгийн барилга төсөв 2024 оны улсын төсөвт тусгагдсан. Тосонцэнгэл сумын 1-р цэцэрлэг АНУ-ын буцалтгүй тусламжаар шинээр баригдаж байгаа 2024 онд

<p>боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах”.</p>		<p>ашиглалтад орно. Улиастай сумын 6-р цэцэрлэгийн барилгын зураг төсвийг шинээр хийлгэж батлуулсан хөрөнгийг асуудлыг шийдвэрлэх, мөн Тосонцэнгэл сумнын 4-р цэцэрлэгийн барилгын зураг төсвийг Дизкон ХХК шинээр хийлгэж байна. Дотуур байрны барилгаас Баянхайрхан, Яруу, Цэцэн-Уул, Тэлмэн, Сонгино, Улиастай сумын Польштехникийн коллежийн дотуур байрны барилга шаардалага хангахгүй ба үүнээс Цэцэн-Уул сумын 100 хүүхдийн дотуур байрны барилга баригдаж 2024 онд ашиглалтад орно. Польштехникийн коллежийн шаардлага хангахгүй хуучин барилгыг буулгаж шинээр 150 хүүхдийн дотуур байрны барилга, Их-Уул сумын сургуулийн дотуур байрны барилга шинээр баригдаж байна. Хөгжим бүжгийн коллежийн дотуур байрны барилгын зураг төсөв шинээр хийгдсэн тендер зарлагдсан гүйцэтгэгч шалгараагүй байна. 2024 оны улсын төсөвт батлагдсан. Сонгино сумын 100 хүүхдийн дотуур байрны зураг төсөв Эрхэс констракшн ХХК-д Идэр сумын 100 хүүхдийн дотуур байрны барилга, Тэс сумын сургуулийн гал тогоо 50 хүүхдийн дотуур байрны өргөтгөлийн зураг тус тус хийгдсэн. Цаашид Баянхайрхан, Тэлмэн, Яруу , Баянтэс сумын сургуулийн дотуур байрны барилгын зураг төсөв хийлгэх шаардалагтай байна.</p> <p>Хичээлийн байры барилгаас 2023 онд Сонгино, Тэлмэн суманд 320 хүүхдийн хичээлийн байр ашиглалтад орсон, Идэр, Баянтэс сумын 320 сургууль, спорт заал, Улиастай сумын 4-р сургуулийн 640 хүүхдийн сургууль,спорт заал, Эрдэнэхайрхан суманд 240 хүүхдийн хичээлийн байрны барилга шинээр баригдаж байгаа ба 2024 онд ашиглалтад орно. Цагаанхайрхан сумын 240, хичээлийн байр, Завханмандал сумын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилгын зураг төсөв хийлгэж 2024 оны улсын төсвийн хөрөнгөд тусгуулсан. Шилүүстэй сумын 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилгын зураг төслийг Дизкон ХХК, Яруу сумын 160 хүүхдийн хичээлийн байр, Ургамал сумын 240 хүүхдийн</p>
---	--	--

			<p>хичээлийн байрны зураг төсөв хийгдсэн. Алдархаан сумын сургуулийн барилгыг зураг төсвийг шинээр хийлгэх шаардлагатай байна.</p> <p>24 сумын сумын сургуулийн спорт заалны барилгаас ашиглалтын шаардлага хангахгүй 11 заалны барилгаас 2023 онд Тэлмэн, Сонгино,Цагаанчулуут 3 сумдын заал шинээр баригдаж ашиглалтад орсон, Отгон, Цагаанхайрхан, Баянтэс, Идэр, Улиастай 2,4-р сургуулийн спорт заалны барилга нийт 6 барилга шинээр баригдаж байна. Завханмандал сумын сургуулийн заал, Улиастай сумын 3-р сургуулийн спорт заал, Ургамал, Шилүүстэй сумын сургуулийн спорт заалны барилгын зураг төсвийн ажил хийгдсэн. Алдархаан Нөмрөг, Тосонцэнгэл сумын 2*р сургуулийн спорт заалны барилгын зураг төсвийг шинээр хийлгэх шаардлагатай. Завханмандал сумын спорт заалны барилгын төсөв, 2024 тусгагдсан.</p> <p>23 сумын соёлын төвийн барилгаас 11 барилга ашиглалтын шаардлага хангахгүй байна. Үүнээс Нөмрөг, Түдэвтэй сумдын соёлын төвийн барилга баригдаж байгаа ба 2024 онд ашиглалтад орно. Дөрвөлжин,Ургамал, Сонгино, Отгон зэрэг 4 сумдын соёлыг төвийн барилгын зураг төслийг шинээр хийлгэж 2024 оны улсын төсөвт хөрөнгийг батлуулсан. Сонгино сумын соёлын төвийн барилгын гүйцэтгэгчээр Ариун-Очир ХХК шалгарч гэрээ хийгдсэн. Дөрвөлжин, Ургамал, Отгон сумдын соёлын төвийн гүйцэтгэгч шалгараагүй байна. Цагаанхайрхан Завханмандал Шилүүстэй сумын соёлын төвийн барилгын зураг төслийг хийлгэж батлуулсан. Цагаанчулуут, сумын соёлын төвийн барилгын зураг төслийг шинээр хийлгэх шаардлагатай байна. Мөн Аймгийн 800 хүний суудалтай соёлын төвийн барилга 2011 онд эхэлсэн ба барилга угсралтын ажил бүрэн дууссан. Тайз технологи интерьер акустикийн ажлын дутуу санхүүжилт 2024 батлагдсан эргэдэг тайз технологийн хэсгийн бэлдэц БНХАУ-д хийгдэж байна. 24 сумын ЗДТГ-с 12 барилга ашиглалтын шаардлага хангахгүй байна. Үүнээс шилүүстэй сумын ЗДТГ-ын барилга баригдаж 2024 онд ашиглалтад орно. Тэлмэн, Сантмаргаз, Баянтэс сумдын ЗДТГ-ын барилгын зураг төсөв хийлгэж 2024 оны улсын төсөвт хөрөнгө</p>
--	--	--	--

			батлагдсан.Сантмаргаз сум ЗДТГ-ын барилгын гүйцэтгэгч Цагаансээр ХХК, Баянтэс сумын ЗДТГ-ын гүйцэтгэгчээр Өнгөт харш ХХК, Тэлмэн сумын ЗДТГ-ын гүйцэтгэгчээр Тэнүүн тэнгис ХХХК тус тус шалгарагн БУА эхлэж байна. 2026 онд ашиглалтад орно. Дөрвөлжин, Улиастай, Асгат, Баянхайрхан, Цагаанхайрхан сумдын ЗДТГ-ын шинэ барилгын зураг төсөв хийгдсэн. Цэцэн-Уул, Сонгино, Их-Уул, Цагаанчулуут сумдын ЗДТГ-ын барилгын зураг төсөв шинээр хийлгэх шаардатай байна.
18	Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. Тухайлбал; - барилгуудын “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-т “Барилгын дулаан хамгаалалтын норм”-ын шаардлагыг бүрэн хангасан байхаар, болон “ногоон” барилгын үзэл баримтлалыг тусган хэрэгжүүлэх.	Орон сууцны болон бусад төрлийн барилгын норм, нормативын баримт бичгийн мөрдүүлэлт, чанар, аюулгүй байдал сайжирсан байна. Мөн Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын даалгаварт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай шаардлага, холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусгаж, хэрэгжүүлэх, хяналт тавин ажилласан байн	2024 онд орон сууцны барилга-5, эрүүл мэндийн байгууллага-1, сургуулийн барилга-1, цэцэрлэгийн барилга-5, соёлын төвийн барилга-1, дотуур байр, гал тогооны барилга-2 бусад-8 нийт 25 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварт Барилгын дулаан хамгаалалтын норм”-ын шаардлагыг бүрэн хангасан байхаар тусган ажлын зургийг батлуулсан. BEST төсөлтэй хамтран 2024 оны 06-р сарын 11-ний өдөр Монголын амины орон сууцны инновац төвөөс эрчим хүчний хэмнэлттэй барилга барилгын дулаан алдагдал бууруулах ногоон барилгын талаар 1 өдрийн цахим сургалтыг Улиастай суманд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж 14 аж ахуйн нэгж байгууллагын ИТА-г хамруулан сургалтыг зохион байгуусан. Мөн ШУТИС-ын эрчим хүчний хэмнэлтийн төвөөс гаргасан 54 ба 36 м2 талбай бүхий амины орон сууцны барилгыг ард иргэдэд ашиглуулах ажлыг охион байгуулан ажилласан.
19	Ашиглагдаж байгаа олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжуудад шинэчилсэн байдлаар үзлэг, тооллого явуулах.	Аймгийн хэмжээнд нэгдсэн тоог шинэчлэн гаргаж, сан байна.	Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа сургууль, дотуур байр, спорт заалны 138 барилга, цэцэрлэгийн 41 барилга, эрүүл мэндийн 44 барилга, үзвэр үйлчилгээ соёлын төвийн 25, ЗДТГ, зочид буудал бусад олон нийтийн барилга-35, орон сууцны -44 барилга үйлдвэрийн барилга-5, сумдын дулааны шугам сүлжээ-24, Алдархаан, Отгон Улиастай, Тосонцэнгэл сумын цэвэр бохир усны шугам, усан сан, цэвэрлэх байгууламж зэрэгт үзлэг тооллого явуулсан.

20	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх.	Зөвшөөрлийн тухай хууль, Хот байгууллатын тухай хууль, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, барилга байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлага хангуулж ажилласан байна. Барилгын үйл ажиллагаанд норм, нормативын баримт бичгийг мөрдүүлсэн байна.	Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу шинээр ашиглалтад орсон болон их засвар хийгдсэн барилга байгууламжид аймгийн Засаг даргын захирамж гаргуулан нийт 6 барилга байгууламжи их засаврын ажлыг ашиглалтад хүлээн авах комиссын үйл ажиллагааг зохион байгуулсан ажилласан. Мөн батлагдсан маягтын дагуу ашиглалтад орсон барилгын мэдээг Барилгын хөгжлийн төвд улирал бүр гарган хүргүүлсэн.
21	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх.	Зөвшөөрлийн тухай хууль, Хот Барилгын тухай хууль болон Тогтоолын хэрэгжилтийг хангуулан барилга байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлага хангуулж ажилласан байна. Уг ажлыг тоо баримттайгаар, бодитой тайлагнаж, улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй болон ашиглалтад орсон, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаарх тайланг нэгтгэж ирүүлсэн байна.	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу шинээр болон их засвар хийгдсэн 50 барилга байгууламжид ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөлийн материалыг бүрдүүлэн авч эхлэх зөвшөөрлийг олгож ажилласан. Мөн ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн мэдээг батлагдсан маягтын дагуу улирал тутамд гаргаж БХТ-д хүргүүлэн ажилласан.
22	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг ирүүлэх.	Тогтоолын хэрэгжилтийг хангуулан барилга байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлага хангуулж ажилласан байна.	2024 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 3250 барилга байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим систем www.urban.gov.mn бүртгээд байна. Мөн 2024 онд шинээр ашиглалтад орсон 10 барилгын мэдээллийг www.urban.gov.mn бүртгээд байна. Барилга байгууламжийн ашиглалтыг ашиглагч байгууллагууд бүрэн хариуцан ажиллаж байна.
23	Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. 2002 оноос өмнөх болон хойших барилга байгууламжийг ангилаж паспортжуулсан байна.	БХБЯ-ны салбарын хяналтын газарт барилгын паспортжуулах ажилд ногоон гэрчилгээ-80ш, шар гэрчилгээ-20ш, улаан гэрчилгээ-10ш тус бүр захиалсан.

	хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах” заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах		
24	Барилга, хот байгуулалтын сайдын “Барилга, байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам батлах тухай” 2016 оны 180 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллах.	Тушаалын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Барилга, байгууламжийн хувийн хэргийн бүртгэл сайжирсан байна.	Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа сургууль, дотуур байр, спорт заалны 138 барилга, цэцэрлэгийн 41 барилга, эрүүл мэндийн 44 барилга, үзвэр үйлчилгээ соёлын төвийн 25, ЗДТГ, зочид буудал бусад олон нийтийн барилга-35, орон сууцны-44 барилга үйлдвэрийн барилга-5, сумдын дулааны шугам сүлжээ-24 барилга байгууламж ашиглагдаж байгаа үүнээс сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн барилгуудад барилгын хувийн хэрэг хөтөлсөн. Засаг даргын Тамгын газар, соёлын төвийн барилга, 50 хувьтай хийгдсэн. Орон сууцны барилга, шугам сүлжээ, үйлдвэрийн барилгад хувийн хэрэг хөтлөөгүй байна.
25	Барилга, байгууламжийн хувийн хэргийг бүрэн цахимжуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх.	Тушаалын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Барилга, байгууламжийн хувийн хэргийн бүртгэл бүрэн цахимжсан байна.	Барилга, байгууламжийн хувийн хэргийг бүрэн цахимжуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх ажил 2024 онд хийгдээгүй хүлээгдэж байна.
26	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтын дагуу барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг албадан буулгах арга хэмжээ авах, мэдээллийг БХБЯ-нд хүргүүлж ажиллах.	Хүн амын эрүүл, аюулгүй байх нөхцөл бүрдэнэ.	2024 оны жилийн эцсийн байдлаар барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй Улиастай сумын Богдын гол багт байрлах Польштехник коллежийн дотуур байр, Баянтэс сумын ЗДТГ, Отгон сумын 50 хүүхдийн цэцэрлэг цагаанчулт сумын 160 хүүхдийн хичээлийн байрны барилга, аймгийн нэгдсэн эмнэлийн 5 авто машины граж, угаалгын барилга зэрэг барилгыг буулгах арга хэмжээ авч ажилласан.
27	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам ”-ын хэрэгжилтийг хангуулж ажиллах.	Барилгын үйл ажиллагааны осол буурсан байна.	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангуулж ажиллах хүрээнд барилгын ажлын талбайд заавал байлгах техникийн баримт бичиг ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагын улсын бүртгэлийн гэрчлгээ, ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагын барилгын ажилгүйцэтгэх тусгай зөвшөөрөлийн гэрчилгээ, захилагч, зөвлөх үйлчилгээ

			<p>үзүүлэгч, гүйцэтгэгч туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагын хооронд байгуулсан гэрээ, барилгын ажил эхлүүлэх үргэжлүүлэх зөвшөөрөл, барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг, барилгын ажлын талбайд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилтаны мэргэжлийн үнэмлэх, магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах арга хэмжээний төлөвлөгөө, барилга угсралтын үе шатны ажилбүр дээр хийсэн эрсдэлийн үнэлгээ, өргөх зөөх тээвэрлэх, хэрэгсэлд, засвар үйлчилгээ, тохируулгыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулж, баталгаажуулсан техникийн магадлагаа, барилга угсралтын ажилгүйцэтгэсэн тэмдэглэл, авулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр, ажилтнуудын цаг ашиглалтын бүртгэлийн дэвтэр зэрэг техникийн баримт бичгийн бүрдэлийн ажил эхлүүлэх үргэжлүүлэх 12 зөвшөөрөл авсан барилга байгууламж дээр хангуулан ажиллаж байна. Мөн MNS7023:2023 стандартын дагуу мэдээллийн самбарыг шинээр баригдаж байгаа барилга байршуулсан.</p>
28	<p>Барилгын материалын лабораторийн итгэмжлэл, тоног төхөөрөмжийн хүчин чадал, ашиглалт, мэргэжилтэй боловсон хүчний ажилласан жил, шинжээчийн сургалтад хамрагдсан эсэх мэдээлэл, сорил шинжилгээний тоо хэмжээ, дүгнэлт бүхий тайланг ирүүлж ажиллах.</p>	<p>Судалгаа мэдээллийн нэгдсэн бүртгэлтэй болсон байна.</p>	<p>Аймгийн ГХБХБГ-ын барилгын материалын лаборатори элс хайрга, цемент, ердийн тоосго, явган замын хавтан, хөнгөн блок, Бетоны орцын норм тогтоох, бетоны бат бэх тодорхойлох зэрэг 8 төрлийн иж бүрэн шинжилгээ хийж үр дүнг баталгаажуулж байна. Хийсэн лабораторийн ажлын шинжилгээ, үр дүнг баталгаажуулах, хийсэн ажлын тайлан хагас бүтэн жилээр гарган хүргүүлсэн.</p>
29	<p>Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах.</p>	<p>Барилгын материалд хийх шинжилгээний нэр төрөл нэмэгдэж, барилгын материалын чанар сайжирна.</p>	<p>2024 онд тоног төхөөрөмж шинээр хангах ажил хийгдээгүй байна. 2025 онд рын орон нутгийн төсөвт 50 сая төгрөг батлуулсан.</p>
30	<p>“Аймгуудын барилгын материалын лабораторийн ажилчдыг чадавхжуулах сургалтанд тогтмол</p>	<p>Барилгын материалд хийх шинжилгээний нэр төрөл нэмэгдэж, барилгын материалын чанар сайжирна.</p>	<p>ГХБХБГ-ын газрын барилгын материал, лабораторын асуудал хариуцсан мэргэжилтэнг 2024.06.20-с 2024.06.27-ны хооронд 7 хоногийн чадавхжуулах сургалтад хамруулсан. Мөн Азийн бетоны 10-р хуралд барилгын материал, лабораторийн асуудал</p>

	хамруулах.		хариуцсан мэргэжилтэн хамрагдсан.
31	Барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүчин чадал, ажиллах хүчний мэдээлэл, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ, тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээтэй эсэх талаар дэлгэрэнгүй судалгаа гарган хагас, бүтэн жилээр “БХТ” ТӨААТҮГ-т ирүүлэх.	Бодлого төлөвлөлтөд шаардагдах суурь судалгаатай болсон байна.	Аймгийн хэмжээнд барилгы материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Бетон төмөр бетон эдлэлийн Арбет ХХК, бетон зуурмагийн үйлдвэрийн Сүм ренбүчи ХХК тус тус 2024 онд тохирын гэрчилгээ авсан. Мөн бетон зуурмагийн үйлдвэрлэлийн чиглэлээр Төгс Түшиг ХХК, Ган доной ХХК тохирын гэрчилгээ авах материал бүрдүүлэн Монголны барилгын материал үйлдвэрлэгчийн холбоо төрийн бус байгууллагад хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд хөнгөн, нүхтэй блок үйлдвэрлэлийн чиглэлээр Бармет Үйл ХХК, Керамик тоосго үйлдвэрлэх чиглэлээр Яруу мандал хоршоо ХХК, Хуванцар цонх үйлдвэрлэх чиглэлээр Оюу гэр ХХК, Дээврийн төмөр үйлдвэрлэлийн чиглэлээр Ханжаргалнт стоунс ХХК, Долистрол хавтан үйлвэрлэх чиглэлээр Завхан сартуул хоос ХХК, Бетонон тоосго, явган замын хавтан, хайрга бутлан ангилах чиглэлээр Боду ХХК тус тус үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа материал үйлдвэрлэгчдийн тусгай зөвшөөрөл, тхирлын гэрчилгээ борлуулалтын мэдээг гарган хагас бүтэн жилээр БХТ ТӨААТҮГ хүргүүлсэн.
32	Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын орд илэрцийн судалгаа гаргах, тухайн оны эрэлт нийлүүлэлтийн судалгааг гаргаж, хагас, бүтэн жилээр “БХТ” ТӨААТҮГ-т ирүүлэх.	Барилгын ажилд шаардагдах эрэлт, нийлүүлэлтийг судалгааны аргачлалд тулгуурласан байх. (харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд)	Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын орд илэрцийн судалгаа гаргаж барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Мөн тухайн оны эрэлт нийлүүлэлтийн судалгааг гаргаж, хагас, бүтэн жилээр “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т хүргүүлсэн.
33	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг Тохирлын үнэлгээнд хамруулан “Тохирлын гэрчилгээ” авах шаардлага тавьж, хэрэгжилтийг хангуулах	Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам”-ын 3.1 заалтын хэрэгжилт хангагдаж, орон нутагт бүтээгдэхүүний чанар дээшилнэ.	Аймгийн хэмжээнд барилгы материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Бетон төмөр бетон эдлэлийн Арбет ХХК, бетон зуурмагийн үйлдвэрийн Сүм ренбүчи ХХК тус тус 2024 онд тохирын гэрчилгээ авсан. Мөн бетон зуурмагийн үйлдвэрлэлийн чиглэлээр Төгс Түшиг ХХК, Ган доной ХХК тохирын гэрчилгээ авах материал бүрдүүлэн Монголны барилгын материал үйлдвэрлэгчийн холбоо төрийн бус байгууллагад хүргүүлсэн.
34	Барилгын салбарт “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” аяныг төлөвлөх, аяныг үр	Аймгийн хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” аян зохион байгуулсан байна	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалаар “Барилга байгууламжийн чанар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” аяныг 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс 12 дугаар

	<p>дүнтэйгээр зохион байгуулах, хэрэгжилтийн тайлан хүргүүлэх.</p>	<p>сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж байгаатай холбогдуулан 4 төрлийн 22 ажил хийхээр төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавин дараах ажлуудыг хийлээ.Үүнд:</p> <p>1.Улиастай суманд шинээр баригдаж байгаа дулааны станцын барилга угсралтын ажлын талбайд 2023 оны 10-р сарын 3-нд өндөрт ажиллаж үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны үзүүлэх, дадлага сургалтыг аймгийн хэмжээнд дэд бүтэц, барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 9 аж ахуйн нэгж байгууллагын 31 инженер техникийн ажилтан ажиллагсадыг хамруулан хийж гүйцэтгэлээ.</p> <p>2.Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Барилга, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр танхимын сургалтыг 27 аж ахуйн нэгж байгууллагын 47 31 инженер техникийн ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанг хамруулан сургалт зохион байгуулан ажиллалаа.</p> <p>3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас 2023 оны 09-р сарын 25-ны өдрийн 02-24-01/075//01 тоотор Барилга угсралтын ажлын чанар, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах тухай зөвлөмж, мөн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай гарын авлага, брошур бэлтгэж барилга угсралтын ажлын гүйцэтгэгч 30 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэн ажилласан.</p> <p>4.Аяны хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд аймгийн 24 суманд байгуулагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн 28 гишүүнд “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм ерөнхий шаардлага БНБД 12-03-04 дүрэм” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулан ажиллалаа. Сургалтаар барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн зааварыг танилцуулж, ажлын байрны зааварчилгаа өгөх аргачилсан заавар өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулан санал солилцож ажиллав.</p> <p>5. Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч “Чандмань цамхаг” ХХК, “Зүр- Өргөө”, “Оч дөл өлзийт” ХХК зэрэг 3 аж ахуйн нэгжийн ажил олгогч эздэд ажил үүргийн</p>
--	--	---

		<p>онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр төрөл, эдэлгээ, чанарын талаар гарсан жагсаалтыг танилцуулан, дагаж мөрдөхийг зөвлөж ажиллалаа.</p> <p>6.Тосонцэнгэл, Баянтэс, Тэс, Ургамал, Завханмандал, Улиастай, Алдархаан, Отгон зэрэг 8 суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга барьж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагын нийт 314 ажилтанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх тухай сургалт зохион байгуулж, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр төрөл, эдэлгээ, чанарын талаар гарсан жагсаалтыг танилцуулж, дагаж мөрдөх тухай зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>7. Аймгийн Улиастай суманд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Алтан харш” ХХК, “Чандмана цамхаг” ХХК, “Оч дөл өлзийт” ХХК, “Зүр өргөө” ХХК, “Эл Си Би” ХХК, “Арь констракшн” ХХК, “Хан жаргалант стоунс” ХХК, “Их хайрхан” ХХК, иргэн Б.Алтангэрэл, иргэн М.Цэрэндорж зэрэг 10 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 07/02 дугаартай албан даалгаварын биелэлтийг хангуулан ажиллалаа.</p> <p>8. Аймгийн барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Алтан харш” ХХК, “Чандмана цамхаг” ХХК, “Оч дөл өлзийт” ХХК, “Зүр өргөө” ХХК, “Эл Си Би” ХХК, “Арь констракшн” ХХК, “Хан жаргалант стоунс” ХХК, “Дайчин хүлэг” ХХК “РСТ” ХХК, Бэрсүм ХХК, “Зуурмаг” ХХК, “Сэрвэн-Овоот” ХХК, “Яруу жаргалтант” ХХК “Цэнхэр тэнгэрийн орон оч” ХХК, Цаст –Уулын оргил ХХК зэрэг 15 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Барилга хот байгуулалтын 2023 оны 10 дугаар сарын 10 өдрийн 2023/03 дугаартай Барилгын ажлын аюулгүй байдлыг хангуулах зарим арга хэмжээний тухай” албан даалгаварын биелэлтийг хангуулан ажиллалаа.</p> <p>9.Барилга салбарын 25 гаруй төлөөлөлд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалгаалсан өвчнөөс ажиллагсдыг сэргийлэх, энэ талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үед авах арга хэмжээ, судлан бүртгэх комиссын үйл ажиллагааг идвэхжүүлэхээр “Үйлдвэрлэлийн осолын шалтгаан, ослоос урьдчилан сэргийлэх нь” 2 цагийн</p>
--	--	---

			<p>танхимын сургалтыг зохион байгуулж, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг зааж, зөвлөгөө өглөө.</p> <p>10. “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ыг 5 аж ахуйн нэгжийн инженерүүдэд сурталчлан ХАБЭА-н удирдлага зохион байгуулалтын менежментийг зөв хийх, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагыг хэрэгжүүлэх хяналт тавих арга техникүүдийн талаар заавар чиглэл өгч ажиллав.</p> <p>11. Улиастай сумын Жинст багт орон сууцны барилгыг байрыг барьж буй “Оч дөл өлзийт” ХХК-д 2023 оны 11 сарын 20-ны өдөр аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлтэй хамтран хяналт шалгалт хийж, дотоод засал, үйлчилгээ хийж буй 32 ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.12. Барилгын гүйцэтгэгч 7. байгууллагуудад “Барилга угсралтын ажлын чанар-Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах тухай” зөвлөмжийг хүргэж, эрсдэлээс урьдчилан сэргийлэн угсралтын ажлын чанар, болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг уриаллаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 07/02 дугаартай албан даалгавар, хууль тогтоомжуудыг сурталчлах чиглэлээр хийгдсэн ажил үйлчилгээнүүдийг байгууллагын цахим хаягт 4 удаа байршуулан ажилласан байна.</p> <p>13. Сарын аяны хаалтын үйл ажиллагааг “Алтан харш” ХХК-ны ажлын байранд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад тулгамдаж буй асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэг, ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг сурталчилах үзүүлэх сургууль хэлбэрээр зохион байгууллаа. Хаалтын үйл ажиллагаанд Аймгийн Барилгачдын холбооны тэргүүн, МУ-ын гавьяат барилгачин Н.Гунаажав үг хэлж, барилгачдын холбооны үйл ажиллагааны талаар танилцуулав. Тус арга хэмжээнд барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлийн 18 аж ахуйн нэгжийн 65 ажилтан оролцож мэдээлэл солилцсон болно. 2024 онд сарын аян зохион байгуулах удирдамж ирээгүй болно.</p>
35	Үйлдвэрлэлийн ослыг бууруулах зорилгоор барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа	Барилга угсралтын үеийн аюулгүй ажиллагааг ханган ажилласан байна.	Аймгийн хэмжээнд шинээр эхлэн баригдаж байгаа барилга угсралтын ажил Улиастай сум 4-р сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байр, Цэцэн-Уул сумын 100 хүүхдийн дотуур байрны барилга, Цагаанхайрхан сумын спорт заалны барилга

	байгууллага аж ахуй нэгжүүдэд барилга угсралтын талбайг камержуулах үүрэг чиглэлийг өгч хэрэгжилтийг хангуулж ажиллах.		Завханмандал сумын 320 хүүхдийн сургууль, Яруу сумын 15 ортой ЭМТ-ийн барилга, Баянтэс сумын 320 хүүхдийн сургууль, спорт заал, Баянтэс, Сантмаргаз сумын иргэдэд үйлчдэх мэдээллийн төвийн барилгуудад хяналтын камерыг суурилуулж ажилласан.
36	Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийг тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах.	Барилга угсралтын аж ахуйн нэгж, байгууллагууд “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт нэвтрүүлсэн байх.	Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийг тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Барилга угсралтын талбайд инженер техникийн ажилчдыг тогтмол ажиллуулах, чадваржуулах мөрдөгдөж байгаа барилгын норм дүрмийг хангаж төслийг чанартай гүйцэтгэхэд анхаарч ажиллахад удирдлага арга зүйн зөвөлгөө өгч ажиллаж байна.
37	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцыг бодлого үйл ажиллагаандаа тусгах, хэрэгжилтийг хангах, тайланг хүргүүлэх.	"Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцын холбогдох зүйл заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.	24 онд Сайдын албан даалгаврыг Барилга угсралтын ажил гүйцэтгэж буй иргэн аж ахуй нэгжүүдэд хүргүүлэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулан ажиллаа. 2024 оны 04 сарын 24-ны Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй аян 2024” хүрээнд барилгын салбарын 48 ажилтанд сургалт зохион байгууллаа.
38	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахтай холбогдуулан төлөвлөж буй барилгын газрын асуудлуудыг шийдвэрлэх.	2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээтэй уялдуулан шаардлагатай газрын асуудлыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж шийдвэрлэж, газрын гэрчилгээг гаргасан байна.	БШУЯ-ны чиглэлээр шинээр зураг төсөв хийгдэх Нөмрөг, Тосонцэнгэл сумын 2, 4 цэцэрлэгийн барилга, Тосонцэнгэл сумын 2-р сургуулийн спорт заал, Тэлмэн, Баянтэс сумын сургуулийн 100 хүүхдийн дотуур байр, Ургамал сумын 240 хүүхдийн хичээлийн байр, спорт заал, Тосонцэнгэл сумын дулаан хангамж, хэрэглээний халуун хүйтэн усны ус гол шугамын ажил, Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн газрын барилга, Улиастай сумын хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн зураг төсөв боловсруулах ажлын техникийн нөхцөл газрын захирамж бүрдүүлэн ажилласан.
39	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахтай холбогдуулан шаардлагатай	2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл арга	БШУЯ-ны чиглэлээр шинээр зураг төсөв хийгдэх Нөмрөг, Тосонцэнгэл сумын 2, 4 цэцэрлэгийн барилга, Тосонцэнгэл сумын 2-р сургуулийн спорт заал, Тэлмэн, Баянтэс сумын

	техникийн нөхцлийн судалгаа хийж олгох асуудлыг шийдвэрлэх.	хэмжээтэй уялдуулан шаардлагатай техникийн нөхцлийг олгох асуудлыг шийдвэрлэх.	сургуулийн 100 хүүхдийн дотуур байр, Ургамал сумын 240 хүүхдийн хичээлийн байр, спорт заал, Тосонцэнгэл сумын дулаан хангамж, хэрэглээний халуун хүйтэн усны ус гол шугамын ажил, Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн газрын барилга, Улиастай сумын хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн зураг төсөв боловсруулах ажлын техникийн нөхцөл газрын захирамж бүрдүүлэн ажилласан.
40	Барилга байгууламжийн зураг төслийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг холбогдох норм, дүрмийн дагуу тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлах, тайлан мэдээг улирал тутам ирүүлэх.	2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж буй барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагыг хангуулж баталсан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар хийт 26 барилга байгууламжийн Барилга байгууламжийн зураг төслийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг холбогдох норм, дүрмийн дагуу тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлахуулах ажлыг зохион байгуулсан.
41	Төлөвлөж буй барилга байгууламжийн төсөл арга хэмжээний зургийн даалгаварыг холбогдох норм, дүрмийн дагуу тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж батлах, тайлан мэдээг улирал тутам ирүүлэх.	2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж буй барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагыг хангуулж баталсан байна.	Аймгийн хэмжээнд шинээр баригдахаар төлөвлөгдөн зураг төсөл хийгдэх 37 барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаварыг тухайн сумын хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу боловсруулан холбогдох албан тушаалтнаар батлуулан ажилласан.
42	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурч боловсроход шаардлагатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг	Аймгийн тусгай хэрэгцээтэй сургуулийн сурагчдийн хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр дэмжлэг үзүүлсэн байна.	Азийн хөгжлийн банзны санхүүжилтээр Аймгийн төв Улиастай суманд шинээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын зураг төслийн ажил ЭМ ЭС ЭЛ ХХК-д хийгдэж барилгын хөгжлийн төвийн магадлалаар хянагдаж байна. Мөн шинээр баригдаж ашиглалтад орсон Цэцэн-Уул сумын 100 хүүхдийн дотуур байр, Баянхайрхан сумын 100 цэцэрлэг, Идэр

	<p>үзүүлэх.</p> <p><i>(Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 15.1.2)</i></p>		<p>сумын 320 хүүхдийн сургууль, Тосонцэнгэл сумын 1- р цэцэрлэг зэрэг барилгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөө, гадна шатны пандусыг норм дормийн дагуу хийж гүйцэтгэгүлэн ашиглалтад хүлээн авсан.</p>
43	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, орон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, салбарт тэдний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд холбогдох арга хэмжээг авах. /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 17 дугаар зүйл/</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн байна.</p>	<p>Аймгийн Засаг даргын 2023 оны 10-р сарын 06-ны өдрийн А/408 тоот захирахамжаар нийтийн зориулалттай барилга байгууламжийн хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй хүртээмжийн байдлыг үнэлэх ажлыг хэсгийг байгуулж Улиастай суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нийтийн үйлчилгээний зах худалдааны төв, явган хүний зам, талбай зэрэг барилга байгууламжийг хамруулсан.</p> <p>Нийтийн зориулалттай барилга байгууламжийн хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжийн байлгах үнэлгээний хуудсыг авто зогсоол, эдэлбэр газрын хүртээмж, барилгын доторх зорчих замын хүртээмж, гол орц, гарц, хонголын хэсэг шат, нүүлгэн шилжүүлэх аюулгүйн бүс, ариун цэврийн өрөө, мэдээллийн хэрэгсэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэхэд тавигдах шаардлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн ажлын байр, зэрэг 11 үнэлэх хуудсаар үнэлсэн. Улиастай суманд үйл ажиллагаа явуулж байгаа 58 байгууллага хамрагдаж үнэлгээ хийхэд 19 хувьтай үнэлэгдсэн байна.</p>
44	<p>Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогын 2.2.5. “эх орны эрдэс, түүхий эдийн нөөцийг үр ашигтай, зохистой ашиглах замаар импортыг орлох, экспортын чиг баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх” зорилтын</p>	<p>Аймгийн бүтээн байгуулалтад шаардлагатай үндсэн нэр төрлийн барилгын материалыг орон нутгаас хангах</p>	<p>Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар барилгын салбарын эдийн засгийн өсөлтийг хангах чиглэлээр аймгийн 5 жилийн үндсэн чиглэлийг батлаж бүтээн байгуулалтын ажлыг эрэмбэлж тухайн онд хийгдэх зураг төслийн зардлыг хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулан шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв болосруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хот байгуулалтын бодлого, төлөвлөлтөд суурилсан орон сууцны үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх</p>

	хүрээнд орон нутагт шинээр байгуулах шаардлагатай барилгын материалын үйлдвэрийн төслийг дэмжиж ажиллах		ажлын хүрээнд Улиастай сумын Өлзийт багт 21-р зуун 800 айлын орон сууцны ехөнхий төлөвлөгөө батлуулан улсын төсвийн хөрөнгөөр гадна цэвэр бохир ус, дулааны шугамыг 4,5 тэрбум төгрөгөөр, гадна цахилгааны шугамын ажлыг 1.6 тэрбум төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Мөн төлөвлөлтийн дагуу 640 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилга, 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсвийг хийлгэж 2024 оны улсын төсөвт хөрөнгийн асуудлыг шийвэрлүүлсэн. Мөн Улиастай сумын 6 багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр бохир усны нэгдсэн системд холобх ажлын зураг төслийг хийж батлуулсан.
НИЙТИЙН АЖ АХУЙ, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР			
45	Сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэл, мэдээллийг цахим хэлбэрт оруулж, тухай бүр баяжилт, хөтлөлтийг гүйцэтгэх	Үйл ажиллагаа явуулж буй Сууц өмчлөгчдийн холбоодын талаарх бүртгэл, мэдээллийг мэдээллийн сангийн бүртгэл хөтлөгдөж, баяжилт хийгдсэн байна.	Улиастай суманд 2024 онд шинээр Жавхлантай Сууц өмчлөгчдийн холбоо шинээр байгуулагдаж Улиастай сумын Жинст, богдын гол багт байрлах нийтийн 42 орон сууцны барилгын цэвэрлэгээ үйлчилгээ, шугам сүлжээний засварын үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Сууц өмчлөгчдийн холбооны бүртгэл, мэдээллийг цахим хэлбэрт оруулж, тухай бүр баяжилт, хөтлөлтийг гүйцэтгэж ажил хийгдэж байна.
46	Шинээр ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшинд хамаарах инженерийн түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж авах, шугам сүлжээний ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулах ажлыг шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулах.	Түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулсан байх.	2023 онд Жинст багт шинээр ашиглалтад орсон Алтанхарш ХХК-ний үйлчилгээтэй 19 айлын орон сууц, Оч дөл өлзийт ХХК-ний 20 айлын орон сууц, 2024 онд ашиглалтад орсон Иргэн Хатбаатарын 25 айлын орон сууц, Иргэн Гомбодоржын 12 айлын орон сууцны байруудыг ашиглалтад хүлээн авч хариуцан ажиллаж байна.
47	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйл, 17, 18, 19 дүгээр зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлэх.	1.Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт; 2.Хуулийн 17, 18 дугаар зүйлийн заалтууд; 3.Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг тус тус хэрэгжүүлсэн байна. 4. Инженер, техникийн ажилтан, ажиллагсдын тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байна.	Нийтийн аж ахуйн Амь-Ус ХХК-ний өмчийн шугам сүлжээ, ус хангамжийн эх үүсвэр цэвэрлэх байгууламж нь орон нутгийн өмчид байдаг. Усны эх үүсвэр байгууламжид халдваргүйжүүлэх төхөөрөмж, НҮБ-н хөрөнгө оруулалтаар 2020 онд тавигдсан хэвийн ажиллаж байна. Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Улиастай сумын 6 багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр бохир усны төвлөрсөн системд холбох зураг хийгдсэн. Үүнээс 2024 оны улсын төсөв Өлзийт

		<p>5.Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулсан байна.</p> <p>6. Ус хангамжийн эх үүсвэрийн байгууламжид унд ахуйн усыг халдваргүйжүүлэх төхөөрөмж, ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжид цэвэрлэгдээд гарч буй усыг халдваргүйжүүлэх төхөөрөмжийг орон нутгийн хөрөнгөөр суурилуулсан байна.</p> <p>7. Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг газрын кадастрын мэдээллийн санд оруулсан байна.</p> <p>8. Монгол Улсын Их хурлын 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүн амын унд, ахуйн усны чанарын асуудлыг бодлогын түвшинд авч үзэн, хэрэгжүүлэх</p>	<p>багийн үйлдвэрийн хэсэг, гэр хороолол албан газруудыг цэвэр усны шугам сүлжээнд холбох ажилд улсын төсөвөөс 7.2 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж гүйцэтгэгчээр Эрин гүрэн ХХК шалгаран эхний ээлийн 2 ба 4-р хэсгийн хийт 6.1 зм цэвэр усны шугамын ажил хийгдсэн.</p>
48	<p>УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6.2.7-д “Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх.</p>		<p>2021 оны улсын төсөвт Улиастай хотын инженерийн барилга байгууламжийн судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажилд 500,0 сая төгрөг батлагдсаны дагуу Улиастай сумын Чигэстэй, Жаргалант, Жинст, Товцог багийн гэр хорооллыг цэвэр, бохир усны шугамд холбох, Товцог багийг нэгдсэн цэвэр усны шугамд холбох ажлуудын зураг төсвийг Некст стейп инженеринг, БХБС-ын багцаас Өлзийт багийн айл өрхүүдийг цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох, Товцог багийн айл өрхүүдийг бохир усны шугам сүлжээнд холбох ажлуудын зураг төсвийг Дөрвөн гүн ХХК-д тус тус хийгдсэн. Аймгийн хэмжээнд 23 сум хувийн хөрөнгө оруулалтаар нэгдсэн дулаан, цэвэр усны шугам сүлжээний ажил хийгдэж бүрэн ашиглалтад ороод байна. Эрдэнэт үйлдвэр ТӨХК-ийн хөрөнгө оруулалтаар сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих үе шаттайгаар хийгдэж байгаа боловч сумын ЗДТГ, ЭМТ, Соёлын төв, хувийн аж ахуй нэгжүүдийн ариутгах татуургын ажил орхигдож байна. сум орон нутгийн төсвөөр Цагаанчулуут, Сонгино сумдын сумын төвийн нэгдсэн ариутгах татуургын шугам, цэвэрлэх зураг төсөв боловсруулах ажлыг хийлгээд байна.</p>

49	Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, биелэлтийг гаргаж ирүүлэх.	Иргэд мэргэжлийн байгууллагаар ус, дулаан хангамж, ариутгах татуурга, нийтийн халуун усаар үйлчлүүлэх нөхцөл бүрдэж, хөрсний бохирдол буурсан байна.	2021 оноос НҮБ-ын төслийн санхүүжилтээр сумдын ундны усны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг мэргэшүүлэх, сумдын ундны усны чанар байдлын судалгаа хийх ажлыг хийж эхэлсэн бөгөөд 24 сумын ундны усны судалгааг гаргаж 2021-2022 онд сумдын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулсан 24 сум хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа төлөвлөгөөтэй болсон. 2024 онд Завханмандал, Цагаанхайрхан суманд шинээр халуун усны барилга барих, Улиастай сумын Чигэстэй багийн халуун усыг нэгдсэн бохир усны шугамд холбох ажил хийхээр хөрөнгө батлаад байна.
50	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжилтийг хангах.	Аймгийн хэмжээнд ундны усны чанарын судалгааг хийлгэж, үүнд үндэслэн ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг шинэчлэн сайжруулсан байна.	Ажил хүлээгдэж байна.
51	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хүрээнд сумдын усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулж, Хууль зүйн яамны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх	Бүх сумдын усны үйлчилгээний тарифыг ХСУХАТАҮЗХ-ны тогтоолоор батлуулсан байна.	Нийтийн аж ахуйн Амь-Ус ХХК Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг 2022 оны 12-р сарын 19-ны өдөр Улиастай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
52	Польш улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих ахуйн бохир усны цэвэрлэх байгууламжийн төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллах.	1. Завхан аймгийн Улиастай суманд шинээр баригдаж буй бохир ус цэвэрлэх байгууламжийн төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулж ажилласан байна. 2. Орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий шинэ цэвэрлэх байгууламжид ажиллах инженер, техникийн ажилтан ажиллагсдыг сургаж дадлагажуулах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлж инженер техникийн ажилтны нөөцтэй болсон байна. 3.Цэвэрлэх байгууламжинд ажиллахаар сургагдсан инженер, техникийн ажилтнуудыг	Бүгд найрамдах Польш улсын Засгийн газрын нөхцөлт зээлийн хөрөнгөөр шинээр баригдах 3000м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламж нь Биологийн цэвэрлэгээний байгууламж бөгөөд лагийг боловсруулж бордоо гаргах, бохир усыг 99 хувьтай цэвэрлэх бөгөөд одоогийн хүчин чадал нь 3 дахин нэмэгдэж байгальд ээлтэй, орчин үеийн агааржуулалтын системтэй, автоматжуулсан цэвэрлэх байгууламж баригдахаар төлөвлөгдсөн. Тус ажлын тендер 2020 онд Барилга хот байгуулалтын яаманд зарлагдаж гүйцэтгэгчээр “Эй Би индастри” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Зураг төслийн Туслан гүйцэтгэгчээр “Чанарын

		<p>тогтвор сууршилтай ажиллах нөхцлөөр ханган ажиллана.</p> <p>4.MNS:6561 стандартын шаардлага хангаагүй хаягдал ус нийлүүлдэг үйлдвэр аж ахуйн нэгжид урьдчилсан цэвэрлэх байгууламж суурилуулах арга хэмжээ авч ажиллах.</p> <p>5.Цэвэрлэх байгууламжийн ашиглалтын жилийн үйл ажиллагааны зардлын эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна.</p> <p>6.Шинээр баригдаж байгаа цэвэрлэх байгууламжийг ашиглалтад орсны дараа ашиглалтын явцад хог хаягдлыг хаях цэг, ландфил байгуулах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх нөхцөлийг бүрдүүлэх,</p> <p>7.Шинээр баригдаж байгаа Польшийн засгийн газрын нөхцөлт зээлийн хүрээнд баригдаж байгаа Цэвэрлэх байууламж ашиглалтад орсоноор зээл төлөлтийг орон нутаг төлнө.</p>	<p>түншлэл” ХХК ажиллаж зураг төсвийн ажлыг гүйцэтгэсэн. Барилга угсралтын ажил 2023 оны 08 дугаар сард эхэлж захиргаа үйлдвэрийн барилгын 1-р давхрын багана, дам нуруу, хучилтын цутгалт, биореакторын барилгын суурийн ажил хийгдэж 2023 оны 9 сарын 26 нд ажил зогссон. Тус төслийн ажлыг орон нутгийн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг Аймгийн засаг даргын 2022.08.18-ны А/426 тоот захирамжаар байгуулсан бөгөөд, төслийн нэгжийг шаардлагатай мэдээ судалгаагаар ханган ажиллаж байна. БХБЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу шинээр баригдах цэвэрлэх байгууламжид ажиллах ИТА-г сургах ажлын хүрээнд ашиглагч байгууллага болох Амь-Ус ХХК-г өдөр тутмын хяналт хийлгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Цэвэрлэх байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд 1.Шугам сүлжээ шинэчлэх ажил 2.Насос станцуудыг засварлах ажил 3.Биоцөөрөм байгуулах ажлуудыг гүйцэтгэх 4,2 тэрбум төгрөг төсөвт тусгагдаагүй бөгөөд хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр 2025 оны улсын төсөвт санал хүргүүлсэн.</p>
53	<p>Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>1.Аймгийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тооллого зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэж үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.</p> <p>2.Судалгаанд үндэслэн “Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага. MNS 5924: 2015” стандартын шаардлагад нийцсэн жорлонг суурилуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p> <p>3.Хэрэгжилтийн мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр ирүүлсэн байна.</p>	<p>Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа нүхэн жорлонгийн тооллого хийгдээгүй. Улиастай сумын 6 багийн гэр хороололд нийтдээ 4600 айл өрх нүхэн жорлон ашиглаж байна. Аймгийн 24 сумаас Улиастай, Тосонцэнгэл, Отгон Алдархаан сумууд бохир усны нэгдсэн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжид холбогдсон. Улиастай сумын 6 багийн айл өрхүүдийн нэгдсэн бохир усны шугамд холбох ажлын зураг хийгдсэн. Богдын гол багийн бор дүнзэн байрны хэсэгт 500 м гадна бохир усны шугам хийгдэж 74 айл бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбогдох нөхцөл бүрдээд байна. Мөн 2024 онд Улиастай сумын Жинст багт 25 айлын орон сууцны барилга ашиглалтад орсон. 2022 онд Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар 13 сумын 43 сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажил хийгдэж хэвийн ажиллаж байна.Төслийн 3-р ээлжинд Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл, Улиастай, Идэр, Нөмрөг, Цагаанчулуут, Шилүүстэй сумдууд хамрагдаж зураг төслийн ажил Ноёдын туур ХХК-д, 4-р ээлжийн ажилд Завханмандал, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Улиастай сумдууд хамрагдаж зураг</p>

			төслийг Хидро инженеринг ХХК тус тус гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. Тус төсөл хэрэгжиж дууссанаар аймгийн бүх сургууль, цэцэрлэг, дотуур байрнууд шаардлагад хангагдсан ариун цэврийн байгууламжтай болох юм.
54	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хэрэгжүүлэх	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солигдсон байна.	2022 онд Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар 13 сумын 43 сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонго ариун цэврийн байгууламжаар солих ажил хийгдэж хэвийн ажиллаж байна. 2023 онд Төслийн 3-р ээлжинд Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл, Улиастай, Идэр, Нөмрөг, Цагаанчулуут, Шилүүстэй сумдууд хамрагдаж зураг төслийн ажил Ноёдын туур ХХК-д, 4-р ээлжийн ажилд Завханмандал, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Улиастай сумдууд хамрагдаж зураг төслийг Хидро инженеринг ХХК тус тус гүйцэтгэж боловсролын ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. Боловсролын ерөнхий газар 4-р ээлжийн ариун цэврийн байгууламжийг ажлын тендерийг зарлаж гүйцэтгэгчээр Универсал инженеринг групп ХХК шалгарсан ажил эхлээгүй байна. 3-р ээлийн ажлын тендер зарлагдаагүй байна.
55	Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдлийн үнэлгээ хийх.	ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу 6 модуль бүхий төлөвлөгөөг боловсруулж эрсдлийн үнэлгээ хийгдсэн байна. Мөн ус бохирдуулагч үйлдвэрүүдийг урьдчилан цэвэрлэх байгууламжтай болгох.	Аймгийн хэмжээнд Улиастай, Тосонцэнгэл, Алдархаан, Отгон зэрэг 4 суманд ариун цэврийн байгууламж ажиллаж байна. Аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдлийн үнэлгээ хагас жилийн байдлаар хийгдээгүй байна.
56	“Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай” Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх.	Төсөвт тусгагдсан хөрөнгийн хэмжээ	“Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай” Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 онд Улиастай сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 50 сая төгрөг батлуулсан.
57	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээ, түүний санхүүжилтийн саналыг тухайн сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн өнөөгийн байдал, боловсруулж батлуулсан ТЭЗУС, ТЭЗҮ, зураг төсөлд үндэслэн	Шаардагдах хөрөнгө санхүүжилтийн тооцоо, судалгаа бүхий саналыг боловсруулан БХБЯ-нд ирүүлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээ, түүний санхүүжилтийн саналыг тухайн сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн өнөөгийн байдал, боловсруулж батлуулсан ТЭЗУС, ТЭЗҮ, зураг төсөлд үндэслэн тооцож сангийн яамны pimis.publicinvestment.gov.mn цахим системт илгээсэн.

	<p>тооцож ирүүлж байх. Ингэхдээ сум, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний судалгаа хийх, зураг төслийг боловсруулах, зөвшилцөх шатанд мэргэжлийн байгууллагуудын саналыг сайтар тусган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн байх.</p>		
58	<p>Аймаг, сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний /ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, үерийн хамгаалалтын далан, суваг г.м/ тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт, үйлчилгээний түвшингийн өнөөгийн байдлыг /чанар, насжилтыг/ тодорхойлсон судалгаа, мэдээллийг БХБЯ-ны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлэх.</p>	<p>Аймаг, сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний /ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, үерийн хамгаалалтын далан, суваг г.м/ тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт, үйлчилгээний түвшингийн өнөөгийн байдлыг /чанар, насжилтыг/ тодорхойлсон судалгаа хийгдсэн байна</p>	<p>Улиастай суманд нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Амь-ус ХХК, Тосонцэнгэл суманд Тосон-Очирт ХХК, Отгон, Алдархаан сумдын инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний /ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга шугамын хүчин чадал, ашиглалт, үйлчилгээний түвшингийн өнөөгийн байдлыг /чанар, насжилтыг/ тодорхойлсон судалгаа, мэдээллийг ХББОСЯ-нд 2024 оны 12-р сарын 02-ны өдрийн 462 тоотоор хүргүүлсэн.</p>
59	<p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймаг, сумдад шинээр болон шилжиж хийгдэхээр тусгагдсан Инженерийн хангамжийн</p>	<p>Инженерийн хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна. Аймаг бүрт иргэдийг орон сууцжуулах төсөл хэрэгжих, хүн амын ажиллаж, амьдрах таатай нөхцөл, хот, суурин газар өргөжин тэлэх боломж бүрдсэн байна. ажлын үр дүнг тайлагнасан байна.</p>	<p>2024 онд Тосонцэнгэл сумын нэгдсэн цэвэр усны шугамын гүний худгаас усан хүрлтэх 680 м хос шугам шинэчлэх, 300 м3, 500м3 2ш усан сангийн доторлогоо хийх, Улиастай сумын Өлзийт багийн 21-р зуун 800 айлын орон сууцны хроррллын ариутгах татуурын</p>

	барилга байгууламж, шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт, үерийн хамгаалалтын далан, сувгийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтран ажиллах, ажлын үр дүнг тайлагнах.		шугамыг Улиастай сумын төв бохир усны шугам сүлжээнд холбох ажлын бохир усны насос станцын барилга, даралттай 1,1 км шугам дулаалгын хамт, Мөн өлкийт багийн айл өрх албан газрыг цэвэр усны шугам холбох эхний ээлжийн 6.1 км цэвэр усны шугам, Ногоон байгууламж бүхий тохижилтын ажлын хүрээнд 7 сумын 8 байршилд 3х3 сагсан бөмбөмгийн талбай ногоог байгууламж бүхий орчны тохижилтын ажлыг хтйж гүйцэтгэсэн.
60	Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрт гэр хорооллын 150-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцлийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах .	Аймгуудын хэмжээнд гэр хорооллын 150 өрх инженерийн сүлжээнд холбогдож, орон сууцны нөхцөл нь сайжирсан байна	Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын бүсчлэлийн тогтолцооны орон нутгийн хөгжлийн төвөөр тогтоосон 6 бүсийн 88 сумын инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл ажлын хүрээнд манай аймгийн бүлэг суурингийн төв Улиастай, Тосонцэнгэл, Шилүүстэй, Завханмандал, Түдэвтэй, Тэс сумдад төрийн албан хаагчийн 8 айлын орон сууцны газар инженерийн дэд бүтцийн мэдээллийг ХББОС яамнд хүргүүлсэн.
61	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.15-д хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт нь аймгийн чиг үүрэгт хамаарах тул үерийн гамшгаас хамгаалах далан,	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийг нэмэгдүүлэх, засвар үйлчилгээ, цэвэрлэгээг хийснээр иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна.	Улиастай сумын Богдын гол багийн төмөр бетон гүүрнээс доош 1,5 км үерийн усны даланг засварлах ажлыг орон нутгийн төсвөөс хийж гүйцэтгэсэн.

	сувгийг төлөвлөх, ашиглах, ашиглалтад байгаа үерийн далан суваг, борооны ус зайлуулах сувгийн засвар үйлчилгээ, лаг хагшаасыг тогтсон хугацаанд цэвэрлэдэг байх, цаашид ашиглалт, үйлчилгээ хариуцах байгууллагыг тодорхой болгон, үерийн эрсдэлээс сэргийлэх.		
62	Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэл хийх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах,	Аймгийн хэмжээнд “Байр зүйн дэвсгэр тоон зураг, дэд бүтцийн мэдээллийн сан” болон “Хот байгуулалтын мэдээллийн сан”-д хот суурин газруудын газар дээрх болон газар доорх инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний мэдээллээр тогтмол баяжилт хийх ажлыг зохион байгуулж бүтэн жилээр тайлагнасан байна.	Инженерийн дэд бүтцийн хэмжээнд Ус хангамж сүлжээний 1046 мэдээлэл, Ариутгах татуургын сүлжээний 626 мэдээлэл, Дэд станы 11 мэдээлэл, Хот байгуулалтын кадастрын цахим систем болох /URBAN.GOV.MN/-д бүртгэгдсэн.
63	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг мэдээллийн санд оруулж, мэдээллийн сангуудыг нэгтгэж, хамгаалалтын зурваст газар олгогдохгүй байх нөхцлийг бүрдүүлэн, ажлыг зохион байгуулах	Хэрэгжилтийг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан байна.	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг мэдээллийн санд оруулах ажил хийгдээгүй болно.
64	Аймгийн хэмжээнд үерийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний эрэмбийг тогтоох, барьж байгуулах шаардлагатай үерийн хамгаалалтын барилга байгууламжийг төлөвлөж хэрэгжүүлэх, иргэдийг үерийн эрсдэлээс хамгаалах	Үерийн эрсдэлийн үнэлгээ хийлгэж шаардлагатай үерийн хамгаалалтын барилга байгууламжийг нэмэгдүүлж, иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна.	2024 онд Завхан аймгийн Жинст багт үерийн голомт дээр сууришсан айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхээр Аймгийн ГХБХБГ-асс шинээр суурьшлын бүс тогтоон ажиллаж байна. Мөн Богдын гол багт 1.5 км урт үерийн далан, Чигэстэй, Жаргалант багт 5 км урт үерийн далангийн зураг төсвийг хийлгүүлэн 2025 оны улсын төсөвт оруулахаар саналыг хүргүүллээ.

	ажлыг зохион байгуулах.		
65	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах.	<p>1.Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.</p> <p>2.Орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий шинэ цэвэрлэх байгууламжид ажиллах инженер, техникийн ажилтан ажиллагсдыг сургаж дадлагажуулах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх давтан сургалтад хамруулж, инженер техникийн ажилтны нөөцтэй болсон байна.</p> <p>3.Цэвэрлэх байгууламжид ажиллахаар сургагдсан инженер, техникийн ажилтнуудыг тогтвор сууршилтай ажиллах нөхцлөөр ханган ажиллана.</p> <p>4. Цэвэрлэх байгууламжийн ажилчдын хөдөлмөрийн нөхцлийг тогтоолгож, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны өвөл, зуны хувцас, хамгаалах хэрэгслээр ханган, цалин хөлсийг нэмэгдүүлнэ.</p> <p>5. MNS:6561 стандартын шаардлага хангаагүй хаягдал ус нийлүүлдэг үйлдвэр аж ахуйн нэгжид урьдчилсан цэвэрлэх байгууламж суурилуулах арга хэмжээ авч ажиллах.</p>	<p>Одоо ашиглагдаж байгаа цэвэрлэх байгууламж нь 2001 онд ашиглалтад орсон. Үүнээс хойш 2015 онд нэг карт нэмж ашиглалтын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <p>Технологи инженерийг бэлтгэсэн. Мөн лабораторын ажилтаныг бэлтгэхээр ажиллаж байна. Томоохон үйлдвэр, аж ахуй нэгжүүдийг бохир усны төв шугамд холбоогүй байгаа. Холбосон нөхцөлд урьдчилсан цэвэрлэх байгууламжийг шаардаж ажиллана.</p> <p>Хөдөлмөр хамгаалалын хувцасыг бэлтгэж, цалин хөлсийг нэмэгдүүлэн ажиллаж байна.</p>
66	Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөл /инженерийн шугам сүлжээ/-ийн эд хөрөнгийн бүртгэл, судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэж тогтмол баяжилт хийж байх.	Хэрэгжилтийг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан байна.	2024 онд шинээр ашиглалтад орсон Иргэн Хадбаатарын 25 айлын орон сууц, Иргэн Гомболржийн 12 айлын орон сууцны байшингийн дундын өмчлөл /инженерийн шугам сүлжээ/-ийн гүйцэтгэлийн зураг хийлгэж , мэдээллийн сан үүсгэж ажилласан.
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР			
67	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хүрээнд улсын төсөв болон	Хөрөнгө өмчлөлд бүртгэгдэж, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирсан байна.	Аймгийн хэмжээнд 2024 оны жилийн байдлаар улсын төсвийн хөрөнгөөр Идэр 320 хүүдийн сургуулийн барилга, Тосонцэнгэл, Баянххайрхан сумын 100 хүүхдийн цэцэрлэг, Цэцэн-Уул сумын 100 хүүхдийн дотуур байрны барилга, Яруу сумын ЭМТ-ийн

	гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон барилга, байгууламжийн ашиглагч байгууллагыг тодорхойлон, өмчлөлд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэн бүртгэх, мэдээ тайланг хагас, бүтэн жилээр ирүүлэх.		барилга, Шилүсстэй сумын ЗДТГ-ын конторын барилга баригдаж ашиглалтад орсон харьяа салбарын яаманд Орон нутгийн өмчийн газартай хамтран хүсэлтээ хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохиуцлалтын яамны шийдэрийг хүлээж байна.
68	Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга, байгууламжийн төсөвт өртгөөс Барилгын тухай хуульд заасны дагуу норм, нормативын санд холбогдох шимтгэлийг төвлөрүүлэх, мэдээ тайланг улирал бүр ирүүлэх.	Орон нутагт баригдаж буй барилга, байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэлийг бүрэн төвлөрүүлсэн байна.	аймгийн хэмжээнд шинээр баригдаж байгаа болон их засвар хийгдэж байгаа 50 гаруй барилга байгууламжийн төсөвт өртгөөс Барилгын тухай хуульд заасны дагуу норм, нормативын санд холбогдох шимтгэлийг төвлөрүүлэх, мэдээ тайланг улирал бүр ирүүлэх. Гарган ажилласан.
69	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт болон явцын гүйцэтгэлийн мэдээ тайланг сар бүр ирүүлэх.	Мэдээ тайланг хугацаанд нь ирүүлсэн байна.	Аймгийн хэмжээнд 2024 онд улсын төсвөөр 40 орон нутгийн төсвөөр 45 гадаадыг зээр тусламжаар 7 барилга байгууламж их засварын ажилд хяналт тавин ажиллаж санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээ тайланг сар бүр гарган аймгийн ЗДТГ, барилгын хөгжлийн төв, боловсролын ерөнхий газарт хүргүүлэн ажилласан.
70	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр шилжин хэрэгжиж буй болон шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан барилга байгууламжийн гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс талуудын харилцан уялдааг хангаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх	Хөрөнгө оруулалтын ажлууд төлөвлөсөн хугацаанд чанартай, үр дүнтэй хэрэгжиж, төсвийн хөрөнгийн үр өгөөж сайжрах нөхцөл бүрдэнэ.	Аймгийн хэмжээнд 2024 онд улсын төсвөөр 40 орон нутгийн төсвөөр 45 гадаадыг зээр тусламжаар 7 барилга байгууламж их засварын ажилд хяналт тавин ажиллаж барилга угсралтын ажлыг гүйцэтгэх явцад тулгамдаж буй асуудлыг зургийн байгууллага, ерөнхий захилагч нартай хамтран асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллаж барилга угсралтыг ажлыг үураг төсөв БНБД, стандартыг хэрэгжүүлэн ажилласан.

	чиглэлээр хамтран ажиллах.		
САЛБАРЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР			
71	“Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 2023/02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах;	Нутаг дэвсгэрийн хэмжээнд албан даалгаварын хэрэгжилт хангагдсан байна.	“2024 онд Завхан аймгийн Жинст багт үерийн голомт дээр сууришсан айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхээр Аймгийн ГХБХБГ-асс шинээр суурьшлын бүс тогтоон ажиллаж байна. Мөн Богдын гол багт 1.5 км урт үерийн далан, Чигэстэй, Жаргалант багт 5 км урт үерийн далангийн зураг төсвийг хийлгүүлэн 2025 оны улсын төсөвт оруулахаар саналыг хүргүүллээ.
72	“Барилгын ажлын аюулгүй байдлыг хангуулах зарим арга хэмжээний тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 2023/03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах;	Нутаг дэвсгэрийн хэмжээнд албан даалгаварын хэрэгжилт хангагдсан байна.	“Барилгын ажлын аюулгүй байдлыг хангуулах зарим арга хэмжээний тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 2023/03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлын төлөтлөгөө гарган батлуулан ажилаж байна.
73	Нутаг дэвсгэртээ барилга, хот байгуулалтын салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичиг, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангуулж, хуулийн дагуу арга хэмжээг авч ажиллах;	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга байгууламжийн чанар, аюулгүй байдал хангагдсан байна.	2024 онд Салбарын хяналтын улсын ерөнхий байцаагчын баталсан удирдамжийн дагуу улсын болон хувийн хөрөнгөөр баригдаж буй нийт 106 объектод хяналт шалгалт хийн салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичиг, стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллаа. Нийт 21 дүгнэлт, 6 албан шаардлага, 4 акт 1 торгууль тавилаа.
74	Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах.	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгосон байна.	Улсын хэмжээнд ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулалтын ажил зогсонги байна. БХБЯ-ны салбарын хяналтын газарт барилгын паспортжуулах ажилд ногоон гэрчилгээ-80ш, шар гэрчилгээ-20ш, улаан гэрчилгээ-10ш тус бүр захиалсан

75	Улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах;	Улсын байцаагчдын мэдлэг, ур чадвар, ажиллах орчин нөхцөл дээшилсэн байна.	2024 онд Сургалтад хамрагдаагүй байна.
СУРГАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ, ХБИ-ИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
76	Барилгын салбарын ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн цахим судалгааг явуулж, мэдээллийн сан бүрдүүлж, нэгдсэн системтэй холбох, ирээдүйд шаардлагатай ажлын байр, мэргэжлийг тодорхойлон БХБЯ-нд ирүүлэх	Ирээдүйд шаардлагатай ажлын байр, мэргэжлийг тодорхойлодог болох	Улиастай сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй 20 аж ахуй нэгжийн 148 ИТА-ын судалгааг гаргаж 2024 оны 05 сарын 06-ны өдөр g.otgontuya@barilga.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. Мөн шаардлагатай байгаа инженер техникийн ажилчдын судалгааг гаргаж хамт Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.
77	Барилга хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах	Сургалт, сургалтад хамрагдсан ажилтнууд, үнэлгээ, хүйсээр ангилсан болон бусад судалгаа, тайлангийн тоо-2	Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа 20 аж ахуйн нэгж байгууллагын инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдын нийт 146 хүний судалгаа гарган Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.
СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР			
78	Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 20... оны хагас, бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-1) болон Ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 20... хагас, бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-2)-г заасан хугацаанд холбогдох газарт тайлагнах;	Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссын дүгнэлт баталгаажсан (нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшин) барилгуудын мэдээлэл бүрдсэн байна.	2024 эхний жилийн эцсийн байдлаар Завхан аймагт Улиастай сумын Жинст багт “иргэн хадбаатар” ХХК-ийн 25 айл, иргэн гомбодрж 12 айл, орон сууцны барилга ашиглалтад орсон бөгөөд судалгааг батлагдсан маягтын дагуу гарган “Барилгын хөгжлийн төв”-д хүргүүлсэн.
79	Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар	Мэдээлэл, бүртгэлийн маягтын дагуу тайлан, мэдээг тогтоосон хугацаанд	Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолын дагуу Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн мэдээ болон

	<p>“Аргачлал батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан “Барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээг ашиглалтад оруулах ажлын хүрээнд барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулах мэдээлэл” маягт, “Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл” маягт, “Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл” маягтын дагуу холбогдох мэдээг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд ирүүлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>ирүүлсэн байна.</p>	<p>ашиглалтад орсон барилгын мэдээг нэгтгэн жилийн эцсийн байдлаар Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл нийт 24, 2023 онд шинээр барилгын ажил эхэлж хот байгуулалтын цахим системээр 8 барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг шинээр олгож, бусад нь барилгын засвар шинэчлэл болон он дамжин хийгдэж байгаа барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн сунгалт нийт 16, Ашиглалтад орсон барилга байгууламж нийт 41 бүртгэл мэдээллийг батлагдсан маягтын дагуу жилийн эцсийн байдлаар гаргаж 2023 оны 12 сарын 14-ны өдрийн 566 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд anonym_ou@yahoo.com мэйл хаягаар хүргүүлсэн.</p>
80	<p>Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 206, А/184 дугаар хамтарсан “Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан маягт, зааврын дагуу тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;</p>	<p>Бүртгэл, мэдээллийн маягт, зааврын дагуу тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.</p>	<p>Аймгийн хэмжээнд барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй-33, барилгын материал үйлдвэрлэлийн-5, зураг төслийн-2 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллалгаа явуулдаг. Дээрх аж ахуйн нэгж байгууллагын мэдээ тайланг нэгтгэн mcis.gov.mn нэгдсэн системд үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнадаг. Хагас жилийн тайлан мэдээг 2024 оны 07 сарын 20-ны өдрийн дотор нэгдсэн мэдээллийн санд тайлагнаж ажилласан.</p>

__oOo__